



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 41

Сангиндалай

Хүүхдийн төлөө зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Хүүхдийн төлөө зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Засаг дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүдэд: Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Сумын Цагдаагийн хэсгийн дарга

ЕБСургуулийн нийгмийн ажилтан

СЭМТөвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын төлөвлөгөөг жил бүрийн оны эхний нэгдүгээр сард багтаан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод, ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН